



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/599

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 04 дугаар “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, 05 дугаар “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Малаас хүнд халдварладаг архаг халдварт бруцеллёз өвчнөөр эрүүл сум, баг, малчин өрхийг баталгаажуулах ажлын удирдамжийг баталж, зохион байгуулахад шаардагдах 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.

4.Удирдамжид заагдсан ажил, арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний ажилд дэмжлэг үзүүлж ажиллахыг Батширээт сумын Засаг дарга (Б.Алтангэрэл)-д, Дадал сумын Засаг дарга (Ш.Мөнххуяг)-д тус тус даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2025 оны
... дүгээр сарын ... -ний өдрийн
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

УДИРДАМЖ

2025 оны 10 дугаар сарын 16

Чингис хот

БАТШИРЭЭТ, ДАДАЛ СУМДЫН ҮХЭР СҮРГИЙГ БРУЦЕЛЛЁЗ ӨВЧНӨӨР ТАЙВАН НЭГЖСҮҮРИЙГ ТОДОРХОЙЛЖ, БАТАЛГААЖУУЛАХ, ТАНДАХ АЖЛЫН ТУХАЙ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Батширээт сум Засаг захиргааны Онон, Барх, Хурх, Норовлин гэсэн 4 багтай. Нийт 766 өрх, 2313 хүн амтай, 497 малчин өрхтэй. 2024 оны тооллогоор 61.3 мянган толгой мал бүртгэгдсэн. Үүнээс 23.9 мянган толгой үхэр бүртгэгдсэн байна.

Дадал сум Засаг захиргааны нэгж буюу Баян-Овоо, Агац, Балж, Онон гэсэн 4 багтай ба нийт 912 өрх 3189 хүн амтай, 528 малчин өрхтэй. 2024 оны тооллогоор 48.4 мянган толгой мал бүртгэгдсэн. Үүнээс 23.5 мянган толгой үхэр бүртгэгдсэн байна.

Монгол улсад бүртгэгдсэн зооноз өвчнүүд дотроос бруцеллёз нь нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд хамгийн их хор хохирол учруулж байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2006-2024 оны байдлаар 158 хүн буюу нийт хүн амын 0.19% нь бруцеллёз өвчнөөр өвчилсөн байна.

Хэнтий аймгийн 18 сумын үхэр сүрэгт 2024 онд хийсэн бруцеллёзын тандалтын шинжилгээний дүнгээс харахад халдварлалтын дундаж түвшин 0.14% байгаа нь дээрх статистик үзүүлэлтээс дүгнэж үзэхэд уг халдвар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Хэнтий аймгийн Батширээт, Дадал сумдын малчин өрхийн үхэр сүрэгт бруцеллёз өвчний тандалт, шинжилгээ хийж, дээрх өвчнөөс эрүүл аж ахуйн нэгж, малчин өрхийг тодорхойлж, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Хүн амын хүнсний хэрэгцээнд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлдэг аж ахуйн нэгж, сүүний тасаг, мал бүхий иргэдэд үхрийн бруцеллёз өвчнөөс эрүүл сүргийн статусыг тогтвортой хадгалах хянах, тайван бус ААН, суурийн халдварыг хянах, цаашид эрүүлжүүлэх нөхцөл бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад энэхүү ажлын зорилго оршино.

ГУРАВ. ЗОРИЛТ

Шинжилгээнд хамрагдсан бүх ААН, суурийн малыг бүртгэлжүүлэх, шинжилгээний дүнг бүртгэл мэдээллийн санд оруулах, малын шилжилт хөдөлгөөн, сүрэг сэлбэлтийг бүртгэх, хянах, мэдээллийг дамжуулах, боломж бүрдүүлэх

Аж ахуй нэгж, иргэдийн үхэрт бруцеллёз өвчнөөр тайван ААН, суурийг тодорхойлох, баталгаажуулах, статусыг тогтвортой хадгалах, хянах нөхцөл бүрдүүлэх

ДӨРӨВ. ХУГАЦАА

Дээрх ажлыг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын 2 хэсэг гарч Батширээт, Дадал сумдад ажиллана. Ажлын явц гүйцэтгэлийн тайланг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор гаргана.

ТАВ. АЖЛЫН ХЭМЖЭЭ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Бруцеллөз өвчний тандалт, шинжилгээнд Батширээт, Дадал сумдын 1025 малчин өрхийн 20207 үхэр (сувай, хээлтэй үнээ, үржилд ашиглаж буй хээлтүүлэгч ашиглаж буй, ашиглахаар төлөвлөж буй бүх мал) хамрагдана. Шинжилгээнд хамрагдсан мал бүрийг бүртгэнэ.

ЗУРГАА. АЖЛЫН АРГА ЗҮЙ

1. Үнээ, хээлтүүлэгч малаас цус авч ийлдсэнд роз бенгалын урвал тавина.
2. Роз бенгалын урвал эерэг гарсан дээжийг ЭЛИЗА-урвалаар баталгаажуулна.
3. Түүнчлэн хээл хаясан, амьгүй төл гаргасан, хаг саатсан, үтрээнээс салс, буртаг, гоожсон гэх мэт шинж тэмдэг үзүүлсэн үнээний үтрээний арчдас зэрэг дээж авч нян судлал болон молекул биологи /Полимеразын гинжин урвал/-ийн аргаар халдварыг баталгаажуулна.
4. Шинжилгээний дээж болон үхрийн бруцеллөз тайван /тайван бус ААН/ суурь бүрийн газар зүйн байршил /GPS/-ыг тэмдэглэн эпидемиологийн зураг гаргах
5. Мал бүхий иргэд, ААН-ийн мэргэжилтэн, ажилтан нарт малын зооноз /бруцеллөз/ өвчний хор хөнөөл, тархах зам, хүн болон малыг халдвараас сэргийлэх, эрүүлжүүлэх арга зам болон ач холбогдлыг сурталчлан зөвлөмж өгөх
6. Шинжилгээгээр сөрөг гарсан ААН /суурийн эзэн, малчинд бруцеллөз өвчнөөр тайван статусаа хадгалахад шаардагдах хариуцлага, үүрэг, гарч болох эрсдэлийг таниулах

ДОЛОО. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Дадал, Батширээт сумын үхэр сүрэгт бруцеллөзоор тайван эсэхийг тодорхойлох.

Ард иргэдэд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлж буй тасаг, ААН-ийн бүх үнээ, хээлтүүлэгч нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэнээр малын шилжилт хөдөлгөөн болон мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэх боломж нээгдэнэ.